



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1,6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр барьж ашиглалтад оруулсан нийт 363,077,846,344.70 (гурван зуун жаран гурван тэрбум далан долоон сая найман зуун дөчин зургаан мянга гурван зуун дөчин дөрвөн төгрөг далан мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021
оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 08 дугаар
тогтоолын хавсралт

КОНЦЕССЫН "БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ" ГЭРЭЭГЭЭР БИЙ БОЛСОН, ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламж /хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ/-ний нэр	Ашиглал танд орсон он	Хөрөнгийн үнэ (төгрөг)	Хүлээн авч ашиглах төсөвт байгууллагын нэр
1	Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто зам	2020	363,077,846,344.7	Зам, тээврийн хөгжлийн яам
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			363,077,846,344.70 (гурван зуун жаран гурван тэрбум далан долоон сая найман зуун дөчин зургаан мянга гурван зуун дөчин дөрвөн төгрөг далан мөнгө)	-